

## “Цөмийн хаягдал” цуврал – 1:

### Монголд цөмийн хаягдал булшлах уу?

*Азийн бүсийн цөмийн хаягдал булшлах цэгийг Монголд байгуулах талаар манайхан гадаад орнуудтай хэлэлцэж эхэлжээ гэсэн түгшүүрт мэдээ саяхны нэг өдөр хэвлэлээр цацагдсан. Сэтгэл сэрдхийлгэсэн энэ мэдээг монголчууд хэрхэн хүлээж авсныг сонирхож үзэхэд асуудлыг бодитоор хүлээн авч, үр дагаврыг нь ухааж ойлгоход олон нийтийн мэдлэг мэдээлэл дутмаг байгаа нь ажиглагдаж байсан. Үнэндээ ч бидний олонхийн хувьд цөмийн эрчим хүч, цацраг идэвхт бодисны тухай мэдлэг арван жилд үзээд мартаж амжсан хими, физикийн хичээлийн хүрээнд байна.*

*Харин энэ байдлыг Монголын төрийн түшээд, албаны зарим хүмүүс овжноор ашиглан, бодит үнэнийг мушгин гуйвуулсан буруу ташаа мэдээлэл тарааж, ард олныг төөрөгдүүлэх арга саам сүвэгчилж байна. Түүнчлэн, Японы Фукушима-Даичи дахь цөмийн станцын ослын утаа замхарч ч амжаагүй байхад манай эрдэмтэд Монголд атомын цахилгаан станц байгуулах нь асар ашигтай хэмээн эрээ цээргүй сурталчилж эхэлсэн нь өөрийн эрхгүй айдас болгоомжлолыг төрүүлж байв.*

*Эх орны минь ирээдүй хойчтой холбоотой чухал асуудлаар ухаалаг, алсын бодолтой шийдвэр гаргахад ард иргэдийн оролцоо туйлын чухал. Тиймээс хүмүүст баримт нотолгоотой, үндэслэлтэй бодит мэдээллийг цогц байдлаар хүргэхийг зорьж энэ нийтлэлийг бичлээ. Ингэхдээ хэн нэгнээс захиалга авсангүй, худал шуугиан дээдээж, хүмүүсийг айлгаж цочоох ч гэсэнгүй. Зөвхөн үнэн зөв, цогц мэдлэгтэйгээр асуудлыг эргэцүүлэн нягталж, мэргэн шийдвэр гаргах боломжийг монголчууддаа олгохыг хүссэн болно.*

*Та бүхэн мэргэн ухаандаа болгооно уу.*

Амарлин

2011 оны 4 сарын 22

Жич: Цувралыг бүрэн эхээр нь [golomt.org](http://golomt.org) дээр нийтлэх болно.

## **Монголд цөмийн хаягдал булшлах тухай хэн хэзээ зарлав?**

Монголд олон улсын цөмийн хаягдал агуулах тухай Nuclear Threat Initiative (NTI) байгууллагын сэтгүүлч Илэйн Гроссманы сурвалжилсан мэдээг (1) хориод хоногийн өмнө Монголын хэвлэлд орчуулж гаргасан билээ. Мэдээг дээрх байгууллагын Global Security Newswire хэмээх нэртэй мэдээллийн цахим хуудсанд нийтэлсэн байсан юм. Эргэн санахад тус дөхөм болох үүднээс орчуулгыг дор хавсаргав.

### **Монголд гадаад орнуудын цөмийн хог хаягдлыг хадгалах агуулах байгуулж болзошгүй байгаа гэж АНУ-ын төрийн өндөр албан тушаалтан мэдэгджээ**

2011 оны 3 сарын 30. Лхагва  
Илэйн М. Гроссман

Эх сурвалж: Global Security Newswire сэтгүүл  
[http://www.globalsecuritynewswire.org/gsn/nw\\_20110330\\_8553.php](http://www.globalsecuritynewswire.org/gsn/nw_20110330_8553.php)

Вашингтон хот–Обамагийн ажлын албаныхан Монгол улстай нэгэн албан бус яриа хэлэлцээр хийж, Төв Азид орших энэ улсад ойролцоох бүс нутгийн улсуудын цөмийн түлшний хаягдлыг хадгалах газар байгуулах талаар ярилцсан хэмээн дээгүүр тушаал хашдаг АНУ-ын дипломатч өчигдөр мэдэгджээ.

АНУ-ын Эрчим Хүчний Яамны ажилтнууд болон Монгол улсын нийслэл Улаанбаатар хот дахь төстэй албаны түшмэдүүдийн хоорондох яриа хэлэлцээр эхний шатандаа явж байгаа бөгөөд АНУ-ын Төрийн Департаментын Цөмийн Эрчим Хүч, Аюулгүй Байдлын албаны захирал Ричард Стратфордын хэлснээр цаашид хэрхэх талаар тодорхой шийдвэр хараахан гараагүй байгаа ажээ.

Ричард Стратфорд нь хоёр жил тутам болдог Карнегийн нэрэмжит Олон Улсын Цөмийн Бодлого Боловсруулагчдын Хурал дээр хэлсэн үгэндээ дээрх бүс нутагт цөмийн хог хаягдал агуулах газар байгуулах нь цөмийн эрчим хүч ашигладаг ч хог хаягдлаа зайлуулах боломж тааруу Тайвань болон Өмнөд Солонгос зэрэг орнуудын хувьд онцгой ач холбогдолтой гэж тэмдэглэжээ.

“Монгол улс бусад орны цөмийн хог хаягдлыг өөрийн нутаг дэвсгэр дээрээ агуулахыг зөвшөөрвөл цөмийн түлшний хаягдлыг хадгалах асуудлыг олон улсын түвшинд шийдвэрлэхэд чиглэсэн эерэг алхам болно гэж би хувьдаа үзэж байна” хэмээн цөмийн эрчим хүчний хамтын ажиллагааны гэрээ зөвшилцлийн тухай хэлэлцэх хуралдааны үеэр Ричард Стратфорд хэлжээ. “Тайвань, Өмнөд Солонгос дахь мэргэжил нэгт нөхдийн минь хувьд цөмийн түлшний хог хаягдлыг хадгалах асуудал бол туйлын хүнд асуудал. Тиймээс миний хувьд ямагт дэмжиж ирсэн энэхүү олон улсын цөмийн хаягдлыг хадгалах газрыг байгуулвал тэдний асуудал шийдвэрлэгдэх юм” гэж Ричард Стратфорд үргэлжлүүлэн ярьжээ.

Стратфорд бол цөмийн эрчим хүчтэй холбоотой худалдааны гэрээ пакт байгуулах гол үүргийг гүйцэтгэгч Вашингтоны итгэмжлэгдсэн төлөөлөгч юм. Тэдгээр гэрээг АНУ-

ын Атомын Эрчим Хүчний тухай хуулийн заалтын нэрээр “123 гэрээ” гэж нэрлэж заншжээ.

АНУ нь Ази дахь зарим нэг худалдааны түншүүддээ, тухайлбал, Өмнөд Солонгос, Тайвань зэрэг улсуудад ураны түлшний савханцар бэлтгэн нийлүүлдэг. Тиймээс хэрэв Монгол улс дээр дурдсан улс орнууд болон бусад улсын хэрэглэсэн АНУ-аас гаралтай цөмийн түлшний хаягдлыг нутаг дэвсгэр дээрээ булшилж хадгалахыг зөвшөөрвөл Вашингтон Улаанбаатар хоёр цөмийн эрчим хүчний худалдааны гэрээ байгуулах ажээ. АНУ-ын Цөмийн Эрчим Хүчний Яамны албаны хүмүүс Монголчуудтай нэлээд хэдэн сарын туршид албан бус яриа хэлэлцээр хийж байгаа хэдий ч Стратфорд өөрөө энэ асуудлаар Улаанбаатартай холбогдож амжаагүй байгаа гэж мэдэгджээ. Мөн цөмийн эрчим хүчний худалдааны пакт албан ёсоор байгуулах эсэх нь одоохондоо тодорхойгүй байгаа юм байна. Тэр бүү хэл, дээрх дипломатчийн хэлж буйгаар өөрөө энэ талаар огт мэдээгүй явж байхад нь хамт ажилладаг хүн нь “Танай Эрчим хүчнийхэн Монгол улстай цөмийн эрчим хүч ашиглах чиглэлээр хамтран ажиллах талаар ярилцаж байгаа шүү дээ” гэж 8 долоо хоног орчмын өмнө хэлснээр анх сонссон гэж тэрбээр Global Security Newswire сэтгүүлд өгсөн ярилцлагандаа тайлбарлажээ. “Ингэж сонсоод би “мэдээгүй байсан юм байна. Одоо мэдсэн юм чинь Монгол улсыг ажлынхаа төлөвлөгөөнд оруулчихья, тэгээд харж л байя гэсэн” гэж Ричард Стратфорд ярьжээ.

Карнегийн нэрэмжит Олон Улсын Энх Тайвны Сангийн Цөмийн Эрчим Хүчний хөтөлбөрийн дэд ажилтан Марк Хиббсын мэдэгдсэнээр АНУ-ын Эрчим Хүчний Яамныхан өнгөрсөн оны намар Монголд айлчилж, албаны хүмүүстэй энэ асуудлаар уулзаж ярилцсан байна. Тэрбээр цөмийн эрчим хүчний асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг удирдсан ажээ. “Хэлэлцээр маш өндөр үр дүнтэй явагдсан. Тэд [Монголчууд] нарийн ширийн зүйл зөндөө ярьсан, маш их мэдээлэл авсан” гэж Хиббс Global Security Newswire-ийн сэтгүүлчид өчигдөр өгсөн ярилцлагандаа дурджээ.

Харь орнуудын хаягдлыг бүү хэл дотоодын цөмийн хаягдлаа удаан хугацаагаар хадгалах асуудал нь дэлхий нийтэд нэлээд ярвигтай асуудалд тооцогддог. Учир нь цацраг идэвхит болон хортой бодис агуулах нь хүн амын эрүүл мэндэд хор хөнөөл учруулж болзошгүй тул тус асуудалд олон нийт туйлын хянуур сэрэмжтэй хандаж иржээ. АНУ-ын тухайд гэвэл цөмийн болон атомын түлшний хог хаягдлыг Невада мужийн Якка ууланд битүүмжлэн булшлах тухай шийдвэрт Обамагийн ажлын албанаас хориг тавьсанаас хойш тодорхой шийдвэр гаргаж чадалгүй өнөөг хүрсэн байна.

Дийлэнх улс үндэстнүүдийн хувьд харь орнуудын цөмийн хаягдлыг улс орондоо хадгалах саналыг хараал зүхэл мэт хүлээж авдаг ажээ. Өмнө нь Оросууд өөрийн нутаг дэвсгэр дээрээ олон улсын цөмийн хог хаягдлын цэг байгуулах талаар хэлэлцэж эхэлсэн боловч дотоодын эсэргүүцэлтэй тулгарсны улмаас асуудал тэгсгээд замхарсан байна. Монголд ч бас асуудал тэр тал руугаа эргэж болзошгүй гэж боддог тухайгаа цөмийн эрчим хүчний шинжээч Жеффри Льюис өгүүлсэн юм. Тэрбээр товч ярилцлага өгөхдөө Стратфордын хэлсэн үгэнд гайхсанаа илэрхийлэхийн сацуу “Монголд цөмийн хаягдлын цэг байгуулна гэж санаж яваа бол өөрсдийгөө хуурсан хэрэг болох байлгүй дээ. Монгол улс бүс нутгийнхаа цөмийн түлшний хаягдлын цэг болохыг зөвшөөрөхгүй л болов уу гэж би бодож байна” гэсэн юм.

Хиббс ярихдаа Монгол улс нь “Орос Хятад гэсэн хоёр том гүрний дунд хавчуулагдсан учраас тухайн бүс нутагт эдийн засгийн байр сууриа тогтоохын тулд яахаас

ч буцахгүй. Цөмийн эрчим хүчний салбарт оролцох оролцоогоо өргөжүүлэх нь Монгол улсдын хувьд эдийн засгийн хөшүүрэг болж болзошгүй юм” гэж хэлсэн юм. Бүс нутгийн шинжээчдийн үзэж буйгаар Монгол улс нь ураны олборлолтоо улам өргөжүүлж, улмаар гадаад орнуудыг цөмийн түлшээр хангаад, хэсэг хугацааны дараагаар ашиглагдсан цөмийн хаягдлыг эргүүлж орон нутагтаа авчрах зэрэг өргөн хүрээний үйлчилгээ үзүүлэхийг сонирхож болох ажээ. Оросын Холбооны Улс, Хятад хоёрын аль аль нь цөмийн түлшийг “түрээслүүлэх” гэж нэрлэдэг энэ аргыг хэрэгжүүлээгүй байгаа энэ үед хэрэв Монгол хэрэгжүүлж эхэлбэл энэ талаар анхдагч болох нь.

Мөн зарим нэг эх сурвалжаас үзвэл Монгол улсын эрчим хүчний хэрэгцээ улам бүр нэмэгдэж байгаа энэ цагт тус хэрэгцээг хангахын тулд Монголын засгийн газар болон бусад албаны хүмүүс цөмийн эрчим хүч хөгжүүлэхийг сонирхож болзошгүй юм байна. Тухайлбал, өнгөрөгч долоо хоногт Монголчууд цөмийн технологийг энхийн чиглэлээр ашиглахад Өмнөд Солонгосчуудтай Харилцан ойлголцох санамж бичиг үзгэлжээ. “Дэлхий нийтэд танигдсан Орос, Франц зэрэг цөмийн эрчим хүч ашиглаж сурсан том гүрнүүдийн олон арван жилийн туршид эзэгнэсэн тоглоомын талбарт Монгол улс орж ашиг орлого олно гэдэгт итгэхэд хэцүү” гэж Олон Улс судлалын Монтерей дэх Хүрээлэнгийн Зүүн Азид Цөмийн Зэвсгийг Үл Дэлгэрүүлэх Хөтөлбөрийг удирдагч Льюис ярьсан юм.

“Угаасаа цөмийн хог хаягдлыг агуулж хадгалах энэ бизнест Монгол улс чухам ямар учраас оролцох гээд байгааг би огт ойлгохгүй байгаа юм” гэж тэрбээр хэлээд “Хэрэв би Монгол улсын удирдагч байсан бол аж үйлдвэрлэлтийн хөрөнгө оруулалтыг цөмийн хаягдал хадгалах үйлчилгээнд бус өөр зөндөө олон зүйлд зарцуулах байсан. Монгол улс нь хөрш зэргэлдээ орнуудынхаа атомын хог хаягдлыг хадгалах цэг болж хувирах нь улс төрийн бодлогын хувьд ч таатай зүйл биш шүү дээ” гэж тэрбээр нэмж хэлсэн юм.

“Баттай баримт нотолгоо–жишээлбэл, Монгол улсын засгийн газраас гаргасан нутаг орноо бүс нутгийнхаа цөмийн хог хаягдлын цэг болгохыг хүсэж байна гэсэн мэдэгдэл ч юм уу нэг тийм нотолгоо үзэхээс нааш аль ч улс орон ийм алхам хийнэ гэдэгт би хэзээ ч итгэж чадахгүй” гэж Льюис ярьсан байна.

“Хэрэв Монгол улс цөмийн түлшний хог хаягдлыг хадгалах цэг болох нь өөрт нь ашигтай гэж үзээд АНУ-тай цөмийн эрчим хүчний худалдааны гэрээ байгуулах аваас Монголд том аз тохионо” гэж Хиббс мэдэгдсэн юм. “АНУ-тай 123 гэрээ байгуулж, АНУ-ын дэмжлэгийг авах нь Монголд их чухал. Монгол улс өрнөдийхөнд элэгтэй улс гэдгээ харуулж байгаа... 123 гэрээ байгуулна гэдэг бол Монгол улсын цөмийн эрчим хүчийг хөгжүүлэх үйл ажиллагааг АНУ дэмжиж байгаа гэсэн үг”. Монгол улс ирээдүйд цөмийн зэвсэг хийхийн тулд атомын эрчим хүчийг сонирхож байгаа гэж бодохгүй байгаагаа Хиббс илэрхийлсэн байна.

“Монголчуудын төлөв байдлаас үзэхэд цөмийн зэвсэг сонирхоно гэж огт санагдахгүй байна. Оросууд эсвэл Хятадуудтай зэвсгээр өрсөлдөхөөр эргүүтэж байснаас 1970 оны Цөмийн Зэвсэг Үл Дэлгэрүүлэх Олон Улсын гэрээнд нэгдсэн улс гэдэг статусаа хадгалж байсан нь Монголчуудад илүү ашигтай” гэж тэрбээр хэлсэн байна.

Харин Льюис энэ талаар ялимгүй өөр бодолтой байлаа. “Монголчууд одоохондоо бөмбөг хийхийг сонирхохгүй байгаа гэж би бодож байна. Гэвч хэрэв Монгол улс уран олборлодог орон байснаа цөмийн хог хаягдал хадгалах агуулах болж хувирвал хүсээгүй байхад нь тийм “эмзэг” байгууламжууд олноороо нэмэгдэж болзошгүй шүү дээ” гэж тэр хэлсэн юм.

Мэдээ гарсны дараахан Монголын нийгэм олон янзаар шуугиж эхэлсэн. Ард түмэн гайхсан, түгшсэн байдалтай хүлээж авсан бол зарим нэг сэтгүүлчид асуудлыг хэт дөвийлгөсөн байдлаар тавьж, нотолгоогүй худал мэдээлэл цацаж, харин холбогдох хүмүүс үгүйсгэснээр нэлээд хэдэн “бор шувуу” нисгэсэн. Ингээд энэ талаар дэс дараалалтай тайлбарлая.

**А. Хэн, хэзээ, хаана юу гэж яриу буюу анх хаанаас эхэлсэн бэ?**

- Хэн:** Ноён Ричард Стратфорд, АНУ-ын Төрийн Департаментийн Цөмийн эрчим хүчний албаны захирал
- Хэзээ:** 2011 оны 3 сарын 29-нд
- Хаана:** Вашингтон ДС хотод болсон Карнегийн Сангийн Олон Улсын Цөмийн Бодлогын Хурал дээр
- Нотлох баримт:** Карнегийн Сангийн цахим сайт дээрх хурлын аудио бичлэг, хурлын протокол (<http://carnegieendowment.org/events/?fa=viewSubEvent&id=43479>)

Карнегийн Сан (*Carnegie Endowment*) хэмээх хувийн байгууллага нь олон улсын эдийн засаг, хууль, улс төр, цөмийн эрчим хүчний бодлого зэрэг асуудлаар засгийн газрын бодлогын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг өндөр нэр хүндтэй, нөлөө бүхий байгууллага юм. Тус Сангаас 2 жилд нэг удаа Олон Улсын Цөмийн Бодлогын Хурал (*Carnegie International Nuclear Policy Conference*) зохион байгуулдаг ба ээлжит хурал 2011 оны 3 сарын 28-29-ний өдрүүдэд АНУ-ын нийслэл Вашингтон ДС хотод болж өнгөрчээ (2).

Чухамдаа 3 сарын 29-ний өдөр болсон “АНУ-ын Цөмийн эрчим хүчний салбарын түншлэл: Хэзээ ба Хэнтэй?” (*U.S. Nuclear Cooperation: How and With Whom?*) гэдэг хэлэлцүүлгийн үеэр тус хуралдаанд мэргэжилтнээр оролцсон АНУ-ын Төрийн Департаментийн Цөмийн эрчим хүчний албаны захирал Ричард Стратфорд Монгол улсын нэр хэд хэдэн удаа дурджээ. Тухайлбал, хэдэн жилийн өмнө Оросууд Америкаас гаралтай ураны хаягдал түлшийг эх орондоо 50 хүртэлх жилээр хадгалахыг зөвшөөрч байсан ч одоо бодлоо өөрчилсөн гэж дурсаад

Монголд олон улсын цөмийн хаягдлын агуулах байгуулах талаар яриа хэлэлцээр хийгдэж байгаа гэжээ.

Энэ дашрамд Карнегийн Олон Улсын Цөмийн Бодлогын Хурлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг авахыг хүсвэл цахим хаягаар орж, дурдсан салбар хуралдааны аудио бичлэг, хурлын протоколыг сонсож, унших боломжтой(3). Хэлэлцүүлгийн протоколын 5 болон 13-14 хуудсанд Монгол улсын тухай бичигдсэнийг дор танилцуулав.

*(Хэлэлцүүлэг эхлэхэд урилгаар оролцож буй мэргэжилтнүүд болох Америк-Солонгосын төвийн захирал, Азийн Сангийн ахлах ажилтан Скотт Снайдер, Арабын Эмиратын Элчин Сайд, Австрийн Вен хот дахь олон улсын байгууллагуудын байнгын төлөөлөгч ноён Алкааби болон АНУ-ын Төрийн Департаментын Цөмийн эрчим хүч, аюулгүй байдал, хамгааллын албаны захирал Ричард Стратфорд нарыг танилцуулна. Хуралдааны аудио бичлэгийн 2 минут 58 секундээс эхлэн Ричард [Дик] Стратфорд ажлаа танилцуулж, цөмийн энергийг ашиглахад энхийн замаар хамтран ажиллах гэрээ буюу “Атомын энергийн хуулийн 123 заалтын нэрээр “123 гэрээ” гэж нэршсэн гэрээ байгуулдаг тухайгаа ярина. Тэрбээр ойрын үед Австрали, Арабын Нэгдсэн Эмират, Йордан, Вьетнам, Армени, Бангладеш, Колумби, Норвег, Тайланд, Тайвань, Өмнөд Солонгос, Хятад зэрэг орнуудын гэрээг шинэчлэх, шинээр байгуулах төлөвтэй гэнэ. Ингээд аудио бичлэгийн 16:11—17:15 минутанд Стратфордын ярьсан үгийг дор орчуулж англи эхийг хавсаргав.)*

**Ричард Стратфорд:** *За өөр ямар улс үлдлээ байз? Аан тийм, Монгол улс. Тиймээ. Яагаад Монгол гэж уу? Тэднийхэн цөмийн эрчим хүч үйлдвэрлэхээр төлөвлөж байгаа юу гэж үү? Үгүй л дээ, гэхдээ Монгол улсад гуравдагч оронд үйлдвэрлэсэн цөмийн хаягдал түлшний агуулах байгуулах эсэх тухай яриа хэлэлцээр хийгдэж байгаа. Хэрэв энэ бүгд амжилттай явагдвал бид АНУ-аас гаралтай материал орж буй бүх оронтой “123 гэрээ” байгуулдаг журамтай. Хаягдал түлшний агуулах руу Тайвань, Өмнөд Солонгосоос материал очих төлөвтэй тул бид Монголтой гэрээ байгуулах шаардлагатай болно.*

**Richard Stratford:** Well, are there others out there? Yes, Mongolia. Whoa. Why Mongolia? Are they planning on going nuclear power? Well, no, but there are discussions about whether or not Mongolia would harbor – or take a spent-fuel storage depot for third-country fuel. Now, if that

works out, we have to have a 123 with any country where U.S.-obligated material is going to. Now, since such a spent-fuel storage facility might take material from Taiwan and South Korea, we'd have to do Mongolia.

Дик Стратфорд хуралдааны 52:43--56:30 минутанд Монголын талаар дахин ярьсныг орчуулж, англи эхийг хавсаргав.

**Асуулт:** *Монтеррейн Хүрээлэн, Жеффри Льюис. Ноён Стратфорд, та түрүүн Монгол улстай “123 гэрээ” байгуулах хэлэлцээр хийж байгаа тухай дурсахад би их гайхсан, тэгээд асууж тодруулах 2 зүйл байна. Та яриандаа гуравдагч орны цөмийн хаягдал түлшийг хадгалах агуулах барих тухай дурдсан-- энэ нь Америкт үйлдвэрлэсэн цөмийн хаягдлыг хэлж байна уу? Мөн Монголчуудад ингэх нь ямар ашигтай юм бэ? Тэд цөмийн түлш үйлдвэрлэх юм уу? Энэ түлшний үйлчилгээний багцанд юу юу багтах вэ?*

**Ричард Стратфорд:** *Энэ асуудал тодорхойгүй байгаа. Надад ирэх 4 жилд гэрээ хийх [орнуудын] жагсаалт байдаг юм, за тэгээд тэр болтол энэ албандаа тэсэх л байх гэж бодож байгаа шүү. Их урт жагсаалт л даа. Тэгээд жагсаалтанд бичигдсэн гэрээний талаар хоёр долоо хоног орчмын өмнө хүмүүстэй ярилцаж байтал нэг нь надад **“Хүүе Дик, танай эрчим хүчнийхэн Монголчуудтай цөмийн хаягдал түлш хадгалах асуудлаар ярилцаж байгаа гэж чи мэдэж байгаа биз дээ”** гэсэн.*

*Би тэгэхээр нь “үгүй, мэдээгүй юм байна” гэсэн. “Тэд тэгээд жинхэнээсээ зөвшөөрч байгаа юм уу?” гэхэд надад “тиймээ, тэд зөвшөөрч байна” гэсэн л дээ. Би “за за” гэсэн, хэрэв тэд жинхэнээсээ зөвшөөрөөд, энэ гэрээ бүтэх юм бол би л лав маш их баярлана, Тайвань болон Өмнөд Солонгосын хамтрагчидын маань хувьд хаягдал түлшний асуудал тун хүнд байгаа. Үнэхээр олон улсын [цөмийн хаягдлын] агуулахтай болчихвол--би хувьдаа тийм юмтай болохыг байнга дэмжиж ирсэн хүн л дээ-- тэдний маань асуудал шийдэгдэнэ гэсэн үг шүү дээ.*

**За тэгээд би юу гэх гээд байна вэ гэвэл энэ бүгд бүтэх юм бол “123” [гэрээ] байгуулна, би бол тэднийг Америкийн үйлдвэрлэсэн хаягдал түлшийг нутагтаа шилжүүлж авахыг дэмжинэ.** *Би урьд нь яагаад ОХУ-тай гэрээ байгуулахыг хүчтэй дэмждэг байсан бэ гэвэл уг нь тухайн үед бид Оростой гэрээ байгуулчихсан бол Америкийн үйлдвэрлэсэн цөмийн хаягдал түлшийг авахад тэд бэлэн байсан юм шүү дээ. Хэдэн жилийн өмнөө, би Олон Улсын Атомын Эрчим Хүчний Агентлагийн Ерөнхий захирлын харьяа ажлын хэсэгт олон улсын байгууламж байгуулах талаар тайлан бичихэд Америкийг төлөөлсөн шинжээчээр орж ажиллаж байлаа. Тэгэхэд Оросын ажилтан хурал дээр миний баруун талд суудаг байсан юм. Тэгээд бид хоёр аар саархан юм ярьж байгаад би түүнээс “Та нар хэзээ ч билээ гадаадад үйлдвэрлэсэн цөмийн хаягдал түлш авна гэсэн юм ярьж байл уу?” гэсэн. Тэр надад “тийм ш дээ” гээд. Би тэгэхээр нь “Орост үйлдвэрлэсэн биш гадаадынхыг уу?” гэж асуухад тэрбээр “тийм”*

гэснээ “гэхдээ хадгалах, дахин боловсруулах зорилгоор авна” гэж хэлсэн. “Хэрэв дахин боловсруулахыг зөвшөөрөхгүй бол тодорхой хугацааны дараа эзэнд нь эргүүлж өгнө” гэж байсан. Би “хэдэн жилийн дараа?” гэж асуусан чинь “50 жил” гэж хариулсан. Миний толгойд “Еэ бурхан минь, Тайвань, Өмнөд Солонгост байгаа хамтрагчид маань цөмийн хаягдлаасаа 50 жил ч болтугай салж, элдэв асуудлаас толгойгоо амраахад ямар их дуртай байх болоо” гэж бодогдсон.

Дараа нь Оросууд бодлоо өөрчилсөн л дөө. Одоо тэд Ангарскт үйлдвэрлэж борлуулсан түлшнийхээ хаягдлыг бол эргүүлж авна, харин гадны хаягдал авахгүй гээд байгаа. Та нарт гэж хэлэхэд би [АНУ-ын] төрийн алба хашихаа болихоороо [ОХУ-ын] “Росатом”-д маркетингийн менежер болох юмсан гэж бодоод байгаа шүү (Инээв). Хэрэв би Оросуудын оронд байсан бол Өмнөд Солонгос, Тайвань зэргийн орнуудад манайхаас цөмийн түлш авбал бид хаягдлыг нь эргүүлж авна, тэгээд танай цөмийн хаягдал одоо байгаа хэмжээнээсээ нэмэгдэхгүй гэсэн санал тавинаа. Тэгээд надтай урт хугацааны гэрээ байгуулж, гадны түлш өндөр үнээр хадгалуулах бол би Орост үйлдвэрлэсэн 4 савханцар тутам гадаадад үйлдвэрлэсэн 1 савханцар авна гэсэн гэрээ хийнээ. Ингэвэл цөмийн хаягдал нэмэгдэхгүй, дээрээс нь аажимдаа багассаар багассаар байхгүй болно гэсэн үг шүү дээ. Би л лав хувьдаа ингэвэл асар их ашигтай гэж боддог, тэгээд тэднийг [Оросуудыг] яагаад энэ чиглэлд ажилладаггүй юм бол гэж гайхаж явдаг.

Q: Jeffrey Lewis, Monterey Institute. I was surprised that you referred to discussions about – this is for Mr. Stratford – I was surprised that you referred to discussions about negotiating a 123 agreement with Mongolia so I had just two points of clarification. You mentioned a depot for third-party spent fuel – would that include U.S.-origin spent nuclear fuel? And what do the Mongolians get out of it? Do they want to do fuel fabrication? What’s the fuel services package?

STRATFORD: That’s not entirely clear. I mention that because I have a list, which I keep with me, of all the agreements that I have to do over the next four years, assuming I hang around that long. And it’s a long list. When I was discussing the list with some people about two weeks ago, someone said, Dick, **you realize that your energy colleagues are having discussions with Mongolia about the possibility of spent-fuel storage?**

And I said, no, I wasn’t aware of that. Are they serious? And the answer was, well, they think so. And I said, well, okay, then if they are and if that pans out, then frankly, I’d be very happy because my Taiwan and South Korean colleagues have a really difficult time with spent fuel. And if there really was an international storage depot, which I have always supported, then that would help to solve their problem.

**So my point is, is if that pans out, then there would have to be a 123 and yes, I would support allowing them to transfer U.S.-obligated spent fuel.** One of the reasons I was such a big supporter of the Russia agreement was, if we had an agreement with Russia, it would have allowed U.S.-obligated spent fuel to go to Russia. Now, some years ago when I was the U.S. expert on the IAEA director general’s panel drafting a report on multinational facilities, my Russian colleague sat to my right in the



meetings.

And we were chatting and I said, didn't you, at one point, talk about taking foreign-origin spent fuel? And he said, well, yeah. And I said, not Russian, but others? And he said, yes. And he said, but that would be for storage and reprocessing. If you don't allow us to reprocess it then you have to take it back at some point. And I said, what's the point? And the answer was 50 years. And I thought, oh my god, my Taiwan and South Korean colleagues would love to get rid of their spent fuel for 50 years and not have to face the issue.

[00:55:25]

But the Russians changed their mind. They're happy to take back fuel that they sell from Angarsk but they're not taking foreign spent fuel. Now, I have to tell you, I've often thought that when I leave the government, I should apply for the job of Rosatom's marketing manager. (Laughter.) Because if I were the Russians, I would approach countries like South Korea and Taiwan and I would say, buy from me and I will take it back and your problem of spent fuel will never get worse. Now, sign a long-term contract with me and pay a premium price for somebody else's fuel and for every four Russian rods I take back, I'll take back one foreign rod. Now you can tell your people not only will your spent fuel problem never get worse, but it will gradually get better until it disappears and there is no problem. I personally think there would be a lot of money in that and I absolutely cannot understand why they haven't moved that direction.

### ***Б. Энэ талаарх мэдээллийг ямар сувгаар цацав?***

2011 оны Карнегийн хурлын ивээн тэтгэгчдийн дунд Цөмийн Аюултай Тэмцэх Санаачлага буюу Nuclear Threat Initiative (NTI) гэгч тус төрийн бус байгууллага байжээ. Байгуулагдсанахаа 10 жилийн ойг энэ жил тэмдэглэж буй NTI нь цөмийн, биологийн болон химийн зэвсгийн аюулыг багасгаж, дэлхий нийтийн аюулгүй байдлыг дээшлүүлэх зорилготой юм. Олон Улсын Энх Тайвны Төлөө Карнегийн нэрэмжит Сангийн ерөнхийлөгч Жессика Матьюз нь NTI-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн ажээ (4).

NTI-ийн ТУЗ-ийн захирлаар АНУ-ын сенатор ч Сэм Нанн болон CNN хэмээх мэдээний сургийг үүсгэн байгуулагч, өглөгийн эзэн Тэд Тернер нар хамтран ажилладаг юм байна. Тэднээс гадна АНУ, ОХУ, Япон, Энэтхэг, Пакистан, Хятад, Йордан, Швед, Франц, болон Их Британий нөлөө бүхий хүмүүс ордогоос заримыг нь дурдвал:

- АНУ-ын Батлан Хамгаалах Яамны төрийн нарийн бичиг дарга асан доктор Вильям Перри

- АНУ, Франц, Орос болон Их Британий засгийн газрын хууль тогтоогчид
- Йорданы өндөр сурвалжит гэр бүлийн гишүүн, ханхүү Эл Хассан бин Татал
- Нобелийн шагналтай эдийн засагч, Харвардын их сургуулийн профессор Амартя Сен
- дэлхийд нэртэй цөмийн физикч, Хятадын ШУА-ийн академич, Ноттингэмийн их сургуулийн захирагч доктор Янг
- НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын тусгай зөвлөх, доктор Нафис Садик гэх зэрэг нэр хүндтэй хүмүүс байдаг байна (4).

ТУЗ-ийн гишүүдэд зөвлөхөөр шинжлэх ухаан, бизнес, олон улсын аюулгүй байдлын асуудлаар салбартаа тэргүүлсэн хүмүүс ажилладаг (эдний дунд АНУ-ын тэрбумтан, өглөгийн эзэн Уоррен Баффет оржээ). NTI-ийн ажилтнууд нь цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх асуудал, олон улсын харилцаа, холбоо харилцаа, аюулгүй байдал, цэргийн, нийгмийн эрүүл мэнд, анагаах ухаан зэрэг чиглэлээр мэргэшсэн, гадаад орнуудад ажиллаж байсан, ажлын өндөр туршлагатай чадварлаг шинжээчдээс бүрддэг ажээ.

### ***В. Монголын хэвлэлд энэ талаар ямар мэдээ гарав?***

Албан ёсны эх сурвалжтай, ил тодорхой, баримт нотолгоотой энэ мэдээллийг Монголын эрх баригчид хэвлэл мэдээллээр удаа дараа үгүйсгэсэн. Бантсандаа ч тэр үү зарим нь буруу зөв юм ярьж ч үзэв. Жишээ нь саяхны “Өнөөдөр” сонинд өгсөн ярилцлагадаа УИХ-ын гишүүн О. Чулуунбат цөмийн хаягдлыг Монголд булахаар Тайваньд гэрээ хийж явсан гэдэг мэдээг үгүйсгэнгээ, *“жорлон, үнс утаа цөмийн хаягдлаас арав дахин хортой”*, *“цөмийн идэвхт хаягдал нь хадгалахад хоргүй, туйлын ашигтай бизнес”* гэж хээвнэг залж байх юм. Ингэхдээ өөрөө энэ талаар судалгаа хийсэн гэв (5).

Цөмийн хаягдлын хор хөнөөл болон жорлон, утаа, үнсний талаар дараагийн нийтлэлд дэлгэрэнгүй өгүүлэх бөгөөд тэдгээрийн хор уршиг цөмийн түлшний хаягдлынхтай зүйрлэшгүй бага гэдгийг энэ дашрамд хэлье. Ер нь ураны олборлолт, боловсруулалт, үйлдвэрлэл, ашиглалтын явцад гарч буй олон төрлийн

цөмийн хаягдал дотроос **цөмийн түлшний хаягдал дээд зэргийн хортойд** ордог ажээ.

УИХ-ын гишүүн О. Чулуунбатын “асар ашигтай” гэж нэрлээд байгаа цөмийн түлшний хаягдлыг булшлах бизнес нь чухам хэнд ашигтай юм бэ? Мэдээж хэрэг, АЦС-ныхаа хөнөөлт хаягдлаас салж буй улс оронд яалт ч үгүй ашигтай. Харин үхэл тээгч цөмийн хаягдлыг асар их өртөг зардал, хэдэн зуун мянган жилийн үүрэг хариуцлага, аюул эрсдэлтэй нь хамт гардаж буй талд ямар бол? Үнэхээр ашигтай байсан бол дэлхийн олон орон авахаар өрсөлдөх байсан болов уу. Гэтэл цөмийн түлшний хаягдлаасаа салахын түүс болсон улс зөндөө ч авч хадгалах эзэн олддоггүйгээс болж цөмийн хаягдлын олон улсын агуулах барих төлөвлөгөө олон жил зөвхөн цаасан дээр байгаа юм бус уу?

Цөмийн түлшний хаягдлын агуулахыг аюулгүйн нарийн журам горимын дагуу байгуулахад асар өндөр өртөг зардал шаардагддаг тул хадгалахад авсан төлбөрийн мөнгө ч хүрэлцэнэ гэдэг эргэлзээтэй. Цөмийн хаягдал хадгалах нь хэзээ хэзээгүй тэсэрч болзошгүй аюулт бөмбөг дээр суухтай утга нэг. Байгалийн гамшиг, террорист халдлага, хүний санамсаргүй алдаа, техник, технологийн эвдрэл гээд асар урт хугацааны туршид юу эс тохиолдохыг тэр гэх вэ. Сүүлийн 25 жилд гарсан хэдэн зуугаар тоологдох атомын осол аваарууд (6) цөмийн энерги хичнээн их **аюултайг**, бас **баталгаагүйг** гэрчилж байна. Золгүй явдал тохиолдож гай гамшиг учирваас түүний хор хөнөөл, аймшигт үр дагавар та биднээр зогсохгүй, бидний үр удам, хойч үеийнхэнд ч **зуун мянган жилээр** нөлөөлнө гэдгийг О.Чулуунбат та судалсан уу?

Монгол улс цөмийн хаягдал хадгалахыг сонирхож байгаа гэсэн мэдээ гарсантай холбогдон хэвлэлд олон янзын нийтлэл гарч байсны зах зухаас толилуулья. Тухайлбал, “Нийгмийн Толь” сонинд Б. Түвшинтөр гэдэг нэрээр маш хачирхалтай мэдээ нийтлэгдснийг дороос үзнэ үү.

**Монголыг ураны хаягдлын цэг болгох сонирхолтой байгаа бололтой**

Өнгөрсөн хоёрдугаар сарын сүүлчээр [www.globalsecuritynewswire.org](http://www.globalsecuritynewswire.org) сайтад Монгол Улсыг олон улсын цөмийн хаягдлын цэг болж магадгүй гэх утгатай нийтлэл тавигдсан. Тэнд өгүүлснээр энэ оны хоёрдугаар сард АНУ-ын ерөнхийлөгч Барак Обамагийн ажлын хэсэг манай улсын төлөөлөгчдийг хүлээн авч Азийн улсуудын цөмийн хаягдлыг хадгалах улс болох асуудлыг хэлэлцсэн аж. Энэ талаарх яриа хэлэлцээр эхний шатандаа явж байгаа, тодорхой шийдэлд хүрээгүй гэнэ.

Дээрх сайтад бичсэнээр АНУ-ын Төрийн Департментын цөмийн эрчим хүчний аюулгүй байдлын албаны дарга Ричард Стратфорд цөмийн хаягдлыг хадгалах Монгол Улсын байр суурийн талаар өөрийн бодлоо дэлгэсэн байна. Тэрбээр “Монгол Улс бусад улсын цөмийн хаягдлыг нутаг дэвсгэр дээрээ байршуулахыг зөвшөөрвөл цөмийн хаягдлыг хадгалах асуудлыг шийдвэрлэсэн томоохон үйл явдал болно.

Энэ нь Тайван, Өмнөд Солонгос шиг цөмийн хаягдлаа хааш нь зайлуулахаа мэдэхгүй байгаа улсад ашигтай боломж” гэжээ. Харин Зүүн Азид цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх хөтөлбөрийг удирдагч Льюс “Монгол Улс цөмийн хог хаягдлыг агуулж хадгалах бизнест яагаад оролцох гээд байгаа нь ойлгомжгүй” гэжээ. **Монгол Улсын төлөөлөгчид энэ оны хоёр, гуравдугаар сард АНУ-д айлчлал хийсэн эсэх талаар Гадаад харилцааны яамын Олон нийттэй харилцах газрын дарга Б.Монхоогоос тодруулахад “Эдгээр сард ямар нэгэн албаны айлчлал хийгдээгүй. Ураныг хадгалах асуудал ч яригдаагүй” гэв.**

Тус яамнаа өчигдөр мэдэгдэл хийхдээ “Монгол Улсад цөмийн хог хаягдал хаяхгүй. Энэ нь манай улсын хуулийг зөрчиж байна” хэмээсэн юм. Тэгэхээр [www.globalsecuritynewswire.org](http://www.globalsecuritynewswire.org) сайт худал мэдээлэл байрлуулсан гэсэн үг үү.

Дашрамд дуулгахад, энэ сайт 2006 онд онд АНУ-ын ерөнхийлөгч асан Жорж Бушийг Иракийн дайныг эхлүүлснийхээ төлөө их хэмжээний мөнгө авсан хэмээн бичиж байжээ. Гэвч энэ нь талаарх шүүхийн шийдвэр гарч сайт ялагдсан байдаг. Тэгэхээр энэ сайтад итгэхэд бэрх юм. Гэхдээ манай эрх баригчдын дунд цөмийн хог хаягдлаар хоолоо олж идэх сонирхолтой бүлэг байхыг үгүйсгэхгүй.

Үүний сацуу, АНУ-ын эрх баригчид цөмийн хаягдлаа Невада мужийн Юкиа ууланд хадгалах асуудлыг 2008 оноос хойш ярилцаж байгаа. Гэвч эл асуудал шийдвэрлэгдэх магаддал тун муу байгаа гэнэ.

Иймээс тус улсын эрх баригчдад цөмийн хаягдлаа хаана хадгалах асуудал толгойны өвчин нь болсон аж. Өөрөөр хэлбэл, АНУ цөмийн хаягдлыг хадгалах шинэ улс хайж байгаа. Тэгвэл дээрх сайтын бичсэнээр манай тал АНУ-тай тохиролцох сонирхолтой буйг үгүйсгэх аргагүй. Бүр цаашлаад Монгол Улсыг ураны хаягдлын цэг болгох сонирхол агуулагдаж байгаа гэхэд хэлсдэхгүй.

Д.Түвшинтөр  
Эх сурвалж: “Нийгмийн толь”

<http://sonin.mn/?p=125608> -с авав.

Тайлбарлавал, сэтгүүлч маань 2011 оны 3 сард болсон олон улсын хурлыг хурлыг “Обамагийн ажлын хэсэгтэй манай улс төрчид 2 сард уулзсан” болгож “андуураад”, өөрийн зохиосон мэдээллээ Гадаад Харилцааны Яамнаас лавласан байх юм. Ингээд мэдээж тэр нь батлагдахгүй болохоор нь NTI буюу [www.globalsecuritynewswire.org](http://www.globalsecuritynewswire.org) худал мэдээлэл цацжээ гэсэн дүгнэлт хийж буйг та нар анзаарсан байх. Түүнчлэн, NTI мэдээллийн байгууллага нь АНУ-ын Ерөнхийлөгч асан Ж. Бушийг гүтгэсэн мэдээ цацсаны улмаас шүүхээр шийтгүүлсэн гэж ор үндэслэлгүй юм бичжээ. Б. Түвшинтөр сэтгүүлч тус мэдээг уншихдаа он сар, эх сурвалжийг андуурч будилав уу эсвэл аль нэг хэсэг бүлгийн захиалгаар мэдээллийг мушгин гуйвуулж, бусдыг гүтгэн гөрдөж, олныг төөрөгдүүлэх гэсэн явууллага явуулж байна уу гэдгийг дор бүрнээ болгоох буй заа. Ямартаа ч улс эх орны ирээдүй хойчийн хувь заяатай холбоотой чухал асуудлаар хэлэлцэж байхад сэтгүүлчид шударга байж, үнэн зөв мэдээллийг нийтэд хүргэхээр шамдах нь чухал болов уу.

Албаны шугамаар тус мэдээллийг үгүйсгэсэн тухай өдөр тутмын сонингуудад нийтэлжээ. Жишээ нь гэхэд, “Өдрийн Сонин”-д гарсан нийтлэлд “...Дээрх асуудлын талаар Гадаад харилцааны яамны Хэвлэл мэдээллийн албаны дарга Б. Доржоос тодруулахаар утсаар холбогдоход “Хэн ч юу гэж ярьж болно шүү” гэсэн юм. Гэхдээ Засгийн газар энэ талаар хуралджээ...” “гэж бичжээ (7). Харин 2011 оны 4 сарын 5-нд “Ардын Эрх” сонинд ийм мэдээлэл тавигджээ.

#### **Цөмийн энергийн газар мэдэгдэл гаргав**

Сүүлийн өдрүүдэд сонин хэвлэл, сайтуудаар “Global Security Newswire”-ийн мэдээллээс иш татсан “Монгол Улсыг цөмийн хог хаягдлын агуулах болгохоор ярилцаж байгаа гэх мэдээлэл цацагдсан юм.

Энэхүү мэдээлэлд “Төв Азийн Монгол Улс нь олон улсын цөмийн хог шаарыг булж далдруулахад хамгийн тохиромжтой агуулах болох нутаг юм. Яг энэ асуудлаар Монголын талтай АНУ-ын Засаг захиргаа албан бус яриа хэлэлцээр хийж байна” гэж дурдсан нь үнэнд нийцэхгүй, албан бус мэдээлэл гэж Цөмийн энергийн газраас мэдэгдэж байна. Уг мэдэгдэлд “Дурдсан асуудлаар гадаадын байгууллага, засаг захиргааны нэгж, хувь хүмүүстэй ямар нэгэн яриа хэлэлцээр хийгээгүй, гэрээ хэлцэл хийх хууль эрх зүйн үндэслэлгүй гэж үзэж байна.

2000 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр батлагдсан “Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох, экспортлох тухай” Монгол Улсын хуулийн 4

дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Аюултай хог хаягдлыг ашиглах, хадгалах, түр байршуулах, устгах зорилгоор Монгол Улсад импортоор оруулахыг хориглоно”, мөн 4.2 дахь хэсэгт “Аюултай хог хаягдлыг Монгол Улсын хилээр дамжуулан тээвэрлэхийг хориглоно” гэж заасан байдаг” гэжээ.

### ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ГАЗАР

Эх сурвалж: <http://economy.news.mn/content/61381.shtml>-с авав.

“Өнөөдөр” сонин 4 сарын 11-ний дугаартаа АНУ-ын ЭСЯ-ны мэдэгдлийг орчуулж нийтэлснийг бүрэн эхээр нь дор тавив.

#### ***АНУ-ын Төрийн департамент монголчуудад хандсан мэдэгдэл гаргажээ***

“Өнөөдөр” сонины энэ сарын 1-ний дугаарт “Монгол Улсыг цөмийн хог хаягдлын агуулах болгоно гэв үү” нэртэй мэдээлэл гарсны дагуу АНУ-ын Төрийн департамент мэдэгдэл гаргасныг манай улсад суугаа АНУ-ын ЭСЯ-ны вэб сайтад байрлуулжээ.

Уг мэдэгдэлд “АНУ, Монгол Улсын хооронд эрчим хүчний бодлогын талаар өргөн хүрээнд хамтран ажиллаж, нэн ялангуяа дахин сэргээгдэх эрчим хүчний технологи, цэвэршүүлсэн нүүрс, дэд бүтэц хийгээд иргэний зориулалттай цөмийн эрчим хүчийг хөгжүүлэх чиглэлээр хамтрах меморандумд 2010 онд гарын үсэг зурсан юм. Олон улсын цөмийн бодлогын Карнегийн бага хурлын үеэр АНУ-ын цөмийн энерги, аюулгүй байдлыг хариуцсан **ажилтны хийсэн мэдэгдэлд харамсаж байгаагаар илэрхийлж байна.** Түүний хэлсэн Монгол Улсыг цөмийн хаягдлын агуулах болгох тухай **яриа буруу юм.**

Бид монголчуудын цөмийн салбар дахь бие даасан идэвхтэй үйл ажиллагааг бүрэн дүүрэн хүндэтгэж үздэг бөгөөд энэ чиглэлээр дэмжлэг туслалцаа үзүүлэн хамтран ажиллахад бэлэн байдаг...” хэмээн дурджээ.

Эх сурвалж: <http://mongolnews.mn/i/18087>

Дээрх мэдээг уншаад АНУ-ын төрийн өндөр албан тушаалтан ажлын хариуцлага алдаж, буруу ярьжээ гэж ойлгосон юм. Ингээд мэдээллийн эхийг англиар нягтлахаар АНУ-ын ЭСЯ-ны цахим хуудсыг сонирхлоо. Гайхалтай нь “Өнөөдөр” сониныхон орчуулахдаа ялимгүй мэт авч чухал утгын алдаа гаргасан байх юм. Жинхэнэ англи эх нь “...[АНУ нь] *Олон улсын цөмийн бодлогын Карнегийн бага хурлын үеэр АНУ-ын цөмийн энерги, аюулгүй байдлыг хариуцсан ажилтны хэлсэн үгийг гадаад орнуудын цөмийн түлшний хаягдлын агуулах барьж байгуулах талаар манай улс Монгол улстай хэлэлцээр хийж байгаа*

*мэтээр ташаа ойлгосон явдалд харамсаж байгаагаа илэрхийлж байна. Энэ бол тийм биш билээ”* гэсэн байна.

#### **U.S. Statement on Bilateral Energy Cooperation**

The United States and Mongolia are actively conducting discussions on a wide range of energy-related issues, including renewable energy technologies, clean coal, infrastructure, regulatory considerations and civil nuclear development. As part of this cooperation, our two countries in 2010 signed a memorandum of understanding on cooperation in the peaceful uses of civil nuclear technology.

**We regret that recent statements** made by a U.S. official responsible for nuclear energy, safety & security during the recent Carnegie International Nuclear Policy Conference **may have been misinterpreted to mean** we are in discussions with Mongolia about the establishment of a storage facility to accept foreign spent nuclear fuel. **That is not correct.** We fully respect that Mongolians are making sovereign decisions about their activities in the nuclear field as they deem necessary, and we stand ready to collaborate with and support them where our interests converge.

As we affirmed most recently at our Annual Bilateral Consultations in Ulaanbaatar on March 11, led by Assistant Secretary of State Kurt Campbell, we consider Mongolia to be an important partner on a wide range of issues, from support for democratic principles to international security to economic and commercial development. Our relationship has only grown stronger since we established formal relations nearly 25 years ago, and our joint commitment to openness, transparency, democratic and market-oriented principles will help us reach even greater heights.

Эх сурвалж: [http://mongolia.usembassy.gov/statement\\_040612.html](http://mongolia.usembassy.gov/statement_040612.html)

Харин энэ завсар мэдээг “худал” гэж зарласан Монголын Засгийн Газар энэ асуудлаар хаалттай хуралдаж байх юм (7). 2011 оны 4 сарын 18-ны өдрийн хаалттай хуралдаан дээр ГХЯ-ны сайд Г. Занданшатар нууц мэдээлэл танилцуулсаныг ч (8) үүнтэй холбоотой гэх юм. Үнэндээ 2010 оны 9-р сард АНУ-ын Эрчим хүчний дэд сайд Дэниел Понеман ирээд Г.Зандашатар сайдтай Цөмийн энергийн асуудлаар Хамтран Ажиллах Ойлголцлын Санамж бичигт гарын үсэг зураад явсан. Энэ айлчлалын хугацаа Илэйн Гроссманы сурвалжлагад дурдсан цаг хугацаатай таарч байгаа. Чухам тэр уулзалтын үеэр хэн юу ярьсан, хэн хэнтэй уулзсан, хэрхэхээр тохирсныг Зандашатар сайд сайн мэдэх учиртай билээ.



УБ. 2010 оны 9 сарын 22. АНУ-ын Эрчим Хүчний дэд сайд Д. Понеман, ГХЯ-ны сайд Г. Занданшатар нар Цөмийн эрчим хүчийг энхийн зорилгоор ашиглах салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурав.

### ***Г. Монголд цөмийн хаягдлыг хадгална гэдэг үнэн үү?***

Дээрх асуултын хариулт хэзээ нэг цагт ил болох бизээ. Ямартаа ч цөмийн хаягдлын асуудал дэлхий нийтийн “шүдний өвчин” болчихоод байгаа энэ үед бусад улс орнууд, тухайлбал, манай ойрын хөрш Өмнөд Солонгос, Тайвань зэрэг орнуудад, ийм сонирхол байдаг нь үнэн. Тэдгээр орнуудын АЦС-ын түлш АНУ-аас гаралтай байдгаас энэ асуудалд Америкчууд оролцох болсон бололтой.

Энэ бүх явдалд бид гадаад орнуудыг, тухайлбал, АНУ, Тайванийг ч буруутгах ёсгүй. Бодож үзвэл, аль ч улс гүрэн нэн түрүүнд өөрийн улс орны эрх ашгийг дээдэлдэг. Тиймээс АНУ, Тайвань өөрсдийн эрх ашгийг бодолцож үзээд, хамгийн оновчтой шийдэл хэмээн үзэж Монголчуудад бизнес санал тавьжээ гэж ойлгож болох юм. Харин тэр саналыг хүлээж авах эсэх нь нийт Монголчуудын сонголт байх учиртай. Мэдээлэл ил тод, чөлөөтэй болсон өнөө цагт нөхцөл байдлыг сайтар судалж, эргэцүүлж, хэлэлцэж байж шийдвэр гаргахыг бид шаардах эрхтэй. Ардчилсан нийгмийн давуу тал бол асуудлыг олонхиороо шийддэгт оршдог гэдэг биш бил үү?



Ер нь бол цөмийн хаягдал нутагтаа сэмхэн булшилж, хялбар аргаар хэтэвчээ зузаатгахыг Монголын эрх мэдэлтнүүд хүсэмжилдэг тухай яриа гараад удаж байгаа. Анхны мэдээг бараг долоон жилийн өмнө буюу 2004 оны 6 сарын 1-нд Цахим Өртөө дээр тавигдсныг олж үзлээ (9). Мэдээнд 2004 оны 5 сард Монголын төрийн албан тушаалтан Оросын Төрийн Думын гишүүн Рафаэль Гимаров гэгчээр зуучлуулан Тайваны цөмийн хаягдлыг Монголын говьд булахаар нууц гэрээ хэлэлцээр хийж явсан тухай бичсэн байх юм. Түүнчлэн 2005 онд судлаач Д. Ганхуяг гуай энэ асуудлыг хөндөн тавьж удирдах хүмүүст бичиж байсан ч хариу өгөлгүй сураг алдарчээ (10).

### ТАЙВАНЫ ЦӨМИЙН ХАЯГДЛЫГ ОРОСУУД МОНГОЛД БУЛНА



*Монгол орны өнөөгийн төр засгийн удирдлага мөнгөний төлөө юу ч хийхээс буцахгүй болсон талаар даян дэлхийгээр мэдэх болж, энэ талаар хятадууд хүртэл шогширон бичиж байна. Эл байдлыг халаглан харсан элэг нэгт монгол хүн дараах нийтлэлийг [Цахим] өртөөнд орчуулж ирүүлснийг ямар ч засваргүйгээр нийтэлж байна.*

*Хятад хэлнээс тоймлон орчуулсан Олоннарс*

2004 оны 5 сарын 28 Дэлхийн Мэдээ сонин

Тайваны АЛИМ сонины мэдээлснээр Оросын Холбооны Улсын Төрийн Дээд Зөвлөлийн (ДУМ) дэд тушаалын нэгэн дарга Рафаэл Гималов тус улсад айлчлахдаа Ерөнхий сайдын зөвлөх Линг Фүшинтэй уулзаж, Тайваны цөмийн хаягдлыг Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлуулах асуудлыг эрчимтэй болгох талаар Ерөнхий сайд Ченг Шьюбианд хүсэлт тавилаа.

Тус агентлагийн мэдээлснээр 1997 онд Орос, Америк, Япон, Өмнөд Солонгос зэрэг улсуудыг хамаарсан СИБИРЬ төслийг хэлэлцэн баталж, түүний дагуу Курилийн арлууд болон Байгаль нуурын ойролцоох газар нутагт цөмийн хаягдлыг газар дор булан хадгалахаар тохирсон байна. Гэвч байгаль орчныг хамгаалагчдын ширүүн эсэргүүцэлтэй тулгарч эл асуудал хойшлогджээ.

Тайваны парламентын 520 гишүүдийн саналаар 5 сарын 19-нд Ерөнхий сайд болсон Ченг Шьюбианд баяр хүргэх үйл ажиллагаанд оролцох өөр зорилгоор хүрэлцэн

ирсний дараа Тайваны Засгийн газартай дээд хэмжээнд хэлэлцэж, цөмийн хаягдлын асуудлыг шийдэхийг Ерөнхий сайдад дамжуулан өгөхийг Гималов эрчимтэй шаардав.

Гималов мөн цөмийн хаягдлын асуудалд Америкчууд хэт хутгалдан оролцож байгааг буруушаан үзэж, Путины даалгавраар эл асуудлыг Оросууд тэргүүлэх хүсэлтэй байгаагаа ярилцахаар ирснээ мэдэгдэв.

Тус агентлаг тайлбар хийхдээ, Гималов эл асуудлыг Ерөнхий сайд Ченг Шьюбианд хүчтэй шаардахаар зөвлөх Линг Фүшинтэй 5 сарын 23-ны оройн 10 цагт Жин Хуа зочид буудалд маш нууц уулзалт хийж, мөн Монгол Улсын төрийн дээд албан тушаалтан тэнд оролцсон байна.

Тухайн албаны хүний мэдээлснээр Оросууд анх тохирохдоо нэгж хаягдлыг 1700 америк доллараар худалдан авахаар бодож байсан бол одоо ханш өсч, нэг хаягдлыг 3000 америк доллароос дээш бодно гэжээ. Учир нь энэ мөнгөний 70 хувийг оросууд 30 хувийг монголчууд авахаар хоорондоо тохирсон байна.

Монгол Улс анх удаагаа оролцож байгаа энэ төлөвлөгөө нь Лан Ю усан онгоцоор Хаваровск далайн боомт хүртэл цөмийн хаягдлыг тээвэрлээд Сибирийн төмөр замаар дамжуулан Монголын нутагт оруулах ажээ.

Гималов АЛИМ сонины сурвалжлагчийг хүлээн авахыг зөвшөөрсөн боловч цөмийн хаягдлын талаар сурвалжлага өгөхийг хүссэнгүй. Ерөнхий сайдын зөвлөх Линг Фүшин эл асуудлаар ямарч шийдвэр гаргахад хүчин мөхөс, зөвхөн дээш дамжуулахаа Гималовт мэдэгдэж, цөмийн хаягдлын асуудлыг шийдэх нь удаашрах төлөвтэй.

Зөвлөх Линг Фүшиний эл асуудлын талаар Цөмийн энергийн газрын дарга Линг Мэншианг "Цөмийн хаягдлыг өөртөө хадгалах арга замыг эхлээд бид хайх хэрэгтэй байна" гэж мэдэгджээ

Эх сурвалж: Цахим Өртөө

<http://tsahimurtuu.mn/main/20040601306.htm>

Дээрх мэдээг албан бус гэвэл баттай эх сурвалж ч бас байна. 2009 оны 6 сард УИХ-ын гишүүн Д. Энхбат “Өдрийн Сонин”-ы сурвалжлагч Б. Жавзмаад ярилцлага өгчээ (11). Д. Энхбат “Уран бол энгийн нэг ашигт малтмал биш, буруугаар ашиглавал дэлхийг сөнөөх чадалтай эд. Цөмийн зэвсэг, цөмийн аюулын тухайд хvн төрөлхтөн мартахын аргагvй сургамжийг Японы Хирошимад хаясан атомын бөмбөг, Украины Чернобылийн атомын станц дэлбэрэлтээс авсан” гээд **авлигад идэгдсэн засаг төрд ураны бизнесийг хариуцуулж болохгүйг анхааруулж, уран ашиглахыг согтуу хүнд машин бариулахтай зүйрлэсэн байна.**

Түүний хийсэн маш ноцтой мэдэгдэл бол УИХ-д **цөмийн хаягдлыг булж болно гэсэн тогтоолын төсөл орж ирээд гишүүд тавь, тавин хувиар тэнцээд энэ төслийг шийдэлгvй орхисон** тухай мэдээлэл юм.

**Монгол цөмийн хаягдлыг булшилдаг орон болж хувирах магадлал өндөр**  
(хэсэгчлэн авав)

...**Д. Жавзмаа**: [Ураны] бодлогын баримт бичигт ураны хаягдал хадгалах тухай өгүүлбэр байсан. Үүнийг юу гэж ойлгох вэ?

**Д. Энхбат**: Өмнө нь цөмийн хаягдлыг булж болно гэсэн тогтоолын төсөл орж ирсэн. Гишүүд **тавь, тавин хувиар тэнцээд** энэ төслийг шийдэлгүй орхисон. Монгол цөмийн эрчим хүчийг хөгжүүлээд атомын цахилгаан станцыг барихаасаа өмнө цөмийн хаягдлыг булшилдаг орон болох магадлал өндөр. Яагаад гэвэл манайхны хяналт сул, өргөн уудам нутагтай, сул мөнгө маш их орж ирдэг.

**Д. Жавзмаа**: Бусад орнууд хаягдал авдаг гэсэн шүү дээ?

**Д. Энхбат**: Дэлхийн бүх орон хаягдал авахаас татгалздаг. Өндөр төлбөрөөр, хадгалалт хамгаалалтын өндөр нөхцлөөр хадгалдаг цөөхөн орон бий. Манайх гялгар уут, хогоо цэгцэлж чадахгүй байгаа улс, юун цөмийн хаягдал агуулах. Цөмийн хаягдал орчин тойрноо олон жил хордуулж байдаг аюултай бодис. Хаягдал нь уранаас илүү хортой. Цөмийн хаягдлын хор хүний генийг хордуулдаг. Уран олборлох, цөмийн хаягдал байршуулах хоёр өөр ажил. Манайх ураны түүхий эдийнхээ хаягдлыг ч буцааж авах ёсгүй. Дэлхийн бусад орон вйлдвэрлэл вйлчилгээгээ дээд зэргээр хөгжүүлж сайхан амьдарч байхад бид яахаараа хамаг юмаа зарж, хордуулж амьдрах ёстой юм бэ. Улс орон ийм замаар явбал мөхдөг гэдгийг Африкийн орнуудын жишээ харуулсан шүү дээ

Эх сурвалж:

<http://enkhbatd.wordpress.com/2009/07/10/авлигад-идэгдсэн-засаг-төр-ураны-бизн/>

Манай улс төрчдийн аль эртнээс газар нутагтаа бусдын цөмийн хаягдлыг булшлахаар сонирхож байсныг эдгээр баримтууд гэрчилж байна. Тэгэхээр УИХ-д он улиран суудаг хууччуул бол энэ талаар анддаггүй баймаар. Сэтгүүлчид маань элдэв янзын “шувуу” нисгэж, үнэн худлын мананд төөрч явахаар хэн, хэзээ тийм тогтоол санаачилсан талаар УИХ орчмоос асуувал нэлээд зүйл тодрох ч юм шиг.

***Д. Одоо бид яахав?***

Олон улсын цөмийн хаягдлыг Монголд булшлах хэлэлцээр хийж байгаа гэсэг мэдээллийг албаны хүмүүс үгүйсгэж, “хуулиар хориотой” гэж булзааруулах үгний цаана хуулийг хүчингүй болгож аваад үзээд алдах далд санаа цухалзаж байна. Үнэндээ тэдэнд *“Бид хэзээ ч бусдын цөмийн хаягдлыг эх нутагтаа булшилж ард түмэн, эх орноо аюул эрсдэлд оруулахгүй. Хэрэв тийм асуудал гарваас ил тод хэлэлцэж байж шийдвэрлэх болно”* гэж нүүр бардам хэлэх зүрх зориг, “совесть” дутаж байна. Гадныхан ч бас үүнийг анзаарчихаж. *“Монгол улс*

*цөмийн хаягдал хадгалах талаар хэлэлцээр хийж байгаа гэсэн мэдээ цацагдсаныг Монгол улсын эрх баригчид албан ёсоор үгүйсгэхдээ аюултай хог хаягдлыг импортлохыг Монгол улсын хуулиар хориглосон тул тэгэх боломжгүй хэмээн тайлбарлаж байна*“ гэж тэд бичжээ (12).

Үүнтэй төстэй эмгэнэлт түүх манай хойт хөрш ОХУ-д болоод өнгөрснийг Монголчууд тэр бүр сонсоогүй байж болно. ОХУ-ын төрийн өмчийн “Росатом” корпораци аюулт бодис импортлохыг хориглосон хуулиа зөрчин байж баруун Европын орнуудын цөмийн түлшний хаягдлыг олон жил нууцаар зөөж, нутагтаа булшилсан түүхтэй. Уралын нуруунаас нааш Сибирийн чигт орших Новоуральск, Зеленогорск, Северск, Ангарск гэх хотууд руу хэдэн арван мянган тонн үхэл таригч ачаа ачигджээ. Эцэс сүүлд нь гэмт үйлдэл илэрч Оросын ард түмэн эсэргүүцэн тэмцсэн ч “Росатом” “эсэргүү” хуулийг даруйхан хүчингүй болгуулж, ОХУ-д гадны цөмийн хог хаягдлыг хадгалж болно гэсэн шинэ хуулийг Төрийн Думаар батлуулж аваад үргэлжлүүлэн зөөж байсан. Оросын ард түмэн, байгаль хамгаалагчид, олон улсын Гринпис байгууллагын Орос дахь салбарынхан олон жил уйгагүй тэмцэж байж байдлыг өөрчилж чадсан тухай дараа дараагийн нийтлэлд дэлгэрэнгүй бичих болно.

Монголд ч энэ түүх давтагдаж болзошгүй бололтой. Өнөөдөр цөмийн хаягдал булшлахгүй гэж ганц баталгаа нь 2000 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр батлагдсан “Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох, экспортлох тухай” Монгол Улсын хууль болжээ. Гэвч хууль биднийг хамгаална гэж гар хумхиж суух хооронд ашиг хонжоо эрэгсэд ар хударгаар маань сэм амжуулах аюул нүүрлэж байна. ***Авлигад идэгдсэн засаг төрд итгэж цөмийн хаягдлын асуудлыг хариуцуулж болно гэж үү?***

**Ашигласан материал:**

1. Elaine Grossman, *Монголд гадаад орнуудын цөмийн хог хаягдлыг хадгалах агуулах байгуулж болзошгүй байгаа гэж АНУ-ын төрийн өндөр албан тушаалтан мэдээджээ / Mongolia Might Store Foreign Spent Nuclear Fuel, Senior U.S. Official Says*. Global Security Newswire. March 30, 2011  
[http://www.globalsecuritynewswire.org/gsn/nw\\_20110330\\_8553.php](http://www.globalsecuritynewswire.org/gsn/nw_20110330_8553.php)
2. Карнегийн Олон Улсын Цөмийн Бодлогын Хурлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг олж уншихыг хүсвэл доорх цахим хаягаар орж үзнэ үү. *2011 Carnegie International Nuclear Policy Conference*. <http://carnegieendowment.org/events/?fa=eventDetail&id=3216>
3. Тус хурлын *U.S. Nuclear Cooperation: How and With Whom? Panel Discussion* салбар хэлэлцүүлгийн аудио бичлэг, протоколыг энэ холбоосоор орж үзэж болно.  
<http://carnegieendowment.org/events/?fa=viewSubEvent&id=43479>  
*Event audio* гэж дараад хэлэлцүүлгийн аудио бичлэгийг сонсох ба *Event transcript* гэж сонгоод хэлэлцүүлгийн протоколыг pdf хэлбэрээр хуулж авах боломжтой.  
Хэлэлцүүлгийн протоколын 5 болон 13-14 хуудсанд Монгол улсын тухай бичигдсэн байна.
4. NTI байгууллагын ТУЗ-ийн захирлууд болон тэдний зөвлөхүүдийн тухай мэдээлэл. *NTI Board of Directors*. [http://www.nti.org/b\\_aboutnti/b1\\_board.html](http://www.nti.org/b_aboutnti/b1_board.html)
5. Го. Энхтөр. “Өнөөдөр” сонины 2011 оны 4 сарын 6-ны дугаар. *О.Чулуунбат: Улаанбаатарын утаа, ил жорлонгоос цөмийн хаягдал арав дахин бага хорттой байдаг*. <http://mongolnews.mn/i/17931>
6. Энэ талаарх мэдээллийг нэгтгэхийг хичээ в. Олон Улсын Гринпис байгууллагын архивт 1945-1996 онд болсон 300 орчим атомын осол аварийн тухай мэдээллийн хуанли маягаар тавьжээ. [http://www.msnbc.msn.com/id/42684102/ns/world\\_news-europe/](http://www.msnbc.msn.com/id/42684102/ns/world_news-europe/)  
Английн “Guardian” сонины цахим сайт дээр 2011 оны 3 сарын 14-нд Саймон Рожерс гэгчийн тавьсан мэдээнээс үзвэл дэлхий даяарх АЦС-уудад 1952 оноос хойш 31 удаагийн осол гарсан гэж бичжээ.

<http://www.guardian.co.uk/news/datablog/2011/mar/14/nuclear-power-plant-accidents-list-rank#data>

Харин Европын орнуудын Atomstopp (Австри), Global 2000 (Австри), WISE (Нидерланд), Sortir de Nucleare (Франц), Friends of the Earth Europe( Европ) зэрэг ТББ-уудын хамтран зохион байгуулсан *Нэг сая Европчууд цөмийн энергийн эсрэг* гэдэг кампанит ажлын цахим сайтыг үзвэл 1986-2007 онуудын хооронд АЦС-ууд дээр томоохон осол 22 удаа гарсан гэнэ. <http://www.million-against-nuclear.net/background/accidents.htm>

7. “Өдрийн сонин”-ы 2011 оны 4 сарын 5-ны дугаар. *Монголын нутагт цөмийн хаягдлыг булшилна гэв үү.* [http://www.dailynews.mn/?vfile=7&vmet\\_id=18274&vmet\\_main=6470&vdate=&vl=archive](http://www.dailynews.mn/?vfile=7&vmet_id=18274&vmet_main=6470&vdate=&vl=archive)
8. Г.Занданшатар нууц мэдээлэл танилцуулжээ. “Ардын Эрх” сонин. 2011 оны 4 сарын 18. <http://politics.news.mn/content/63311.shtml> ---с авав
9. Тайваны хаягдлыг Оросууд Монголд булна. Хятад хэлнээс орчуулсан Олоннарс. 2004 оны 6 сарын 1-нд Цахим Өртөө дээр нийтлэгдсэн. <http://tsahimurtuu.mn/main/20040601306.htm>
10. Судлаач Д. Ганхуяг. *Цөмийн хаягдал аль эртнийх....* 2011 оны 4 сарын 2-нд нийтлэгдсэн. <http://gankhuyag.wordpress.com/2011/04/02/hjdhei/>
11. Д. Жавзмаа, “Өдрийн Сонин” 2009 оны 6 сар. *Монгол цөмийн хаягдлыг булшилдаг орон болж хувирах магадлал өндөр.* <http://enkhbatd.wordpress.com/2009/07/10/аелугаад-идэгдсэн-засаг-төр-ураны-бизн/> -с авав.
12. Jonathan B. Miller, *Монгол дахь ураны дуулиан / Mongolia's Uranium Boom.* World Politics Review. 2011 оны 4 сарын 18. <http://www.unuudur.com/?p=14871> --с авав.